



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 8/48

Далгэрхаан сум

Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх  
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 1.2, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 сарын 19-ний 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан ан агнах, барих, арга хэмжээг үндэслэн сумын нутаг дэвсгэр болон тусгай хамгаалалттай газар нутагт Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Ойн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай болон бусад хуулиуд, тэдгээрт нийцүүлэн арга хэмжээг зохион байгуулж, шаардагдах 260,380 (хоёр зуун жаран мянга гурван зуун наян) төгрөгийг зарцуулсугай.

2.Хяналт шалгалтыг хуулийн дагуу, зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 1.1 дэх заалтын дагуу санхүүжүүлэхийг Засагт даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт даалгасугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН



2326010096

